



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/547

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 4.3 4.4 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн хэмжээнд сумдад үйл ажиллагаа явуулж буй Ойн мэргэжлийн байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч : П.Мөнхжаргал /Байгаль орчны газрын дарга/


Гишүүд : А.Даваадорж /Байгаль орчны хяналтын Улсын байцаагч/
О.Батчулуун /Ой алба нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн/
Тухайн сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн/...../
Тухайн Сумын байгаль хамгаалагч /...../
Сум дундын ой анги инженер /...../
Нөлөөлөл бүхий орчинд оршин суугч иргэдийн төлөөлөл /...../

Нарийн бичгийн дарга: Н.Батбаясах /ашиглалт хариуцсан мэргэжилтэн/

2. Ажлын хэсгийг хүлээн авч үр дүнг тооцож тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Хадбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ